



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 31 өдөр

Дугаар

A/08

Амардалай

Ажлын тусгай горимд шилжүүлсэн хугацааг  
сунгах тухай

Монгол улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4.2, Монгол улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22 ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 102 дугаар тогтоол, Онцгой байдлын Ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг ажлын тусгай горимд шилжүүлэх, ажиллуулах журам”-ын 2.4, 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


Нэг: Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацааг сунгахтай холбогдуулан байгууллагын үйл ажиллагааг ажлын тусгай горимд шилжүүлэх хугацааг 2020 оны 04-р сарын 30 ны өдөр хүртэл сунгасугай.

Хоёр: Ажлын тусгай горимд шилжих үеийн удирдамжийг 1 дүгээр хавсралтаар, 0-12 насны хүүхэдтэй ээжүүд, жирэмсэн эхчүүдэд 04-р сарын 06 наас 04-р сарын 20 ны хооронд гэрээсээ албан ажлаа цахимаар гүйцэтгэх боломжоор хангагдах албан хаагчдын нэрсийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Гурав: Нийт ажиллагсадын ажлын цагийн хуваарийг өглөө 09.00-13.00, өдөр 14.00-16.00 цагаар баталсугай.

Дөрөв: Ажлын тусгай горимд шилжсэн үеийн цалин, хөлсийг бүрэн олгохыг нягтлан бодогч /Д.Долгорсүрэн/- д зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.НАРАНТУНГАЛАГ

4880600034